

**Монголын эзэнт гүрний үеийн
нийгмийн холбогдолтой үг хэллэгийн сан дахь түрэг үгс¹**

Монголын эзэнт гүрэн нь урьд оршин тогтнож байсан эртний түргийн хаант улсын төрийн соёлын өвийг уламжлан авсан нь маргаангүй зүйл билээ. Тус өгүүллийн зорилго бол Монголын эзэнт гүрэн, түүний ихэс дээдсийн дотор түрэг хэлтэй хэсэг бүлгийнхний оролцоо багагүй байсны гэрч баримт хийгээд түүний улс төрийн соёл дахь тусгалыг нээн үзүүлэх явдал юм. Монголын эзэнт гүрний эрх баригч удирдагчид түрэг, монгол гэсэн хоёр өөр угсаатны төлөөллөөс бүрэлдэж байсныг тэдний анхдагч өвөг дээдсийн нэр Бөртэ-Чино болон Гоа-Марал харуулдаг. Чингис хааны язгуур *Бөртэ-Чино*, түүний гэргий *Гоа-Марал* нарын нэрсийн эхний хэсэг нь эх хэлээрээ, харин хоёр дахь нь ураг холбосон хүнийхээ хэлээр өгсөн амьтны нэр байсныг тэмдэглэх хэрэгтэй. *Бөртэ* гэдэг бол түрэг хэлнүүдэд “чоно”, харин *Гоа* гэдэг нь монгол хэлээр (манж-түнгүс хэлнүүдэд ч адил) “марал, согоо” гэсэн утгатай². [Крадин, Скрынникова 2006:187]. Түүнчлэн *Бөртэ-Чино* гэдэг бол “Чоно-Чоно”, харин *Гоа-Марал* гэдэг нь “Марал+Марал” гэсэн утгатай болох төдийгүй *Гоа* хэмээх нэр оролцсон тохиолдолд монгол хүний эхнэр болохыг тодорхойлдог байсан нь дараах нэрсэд үлджээ. Үүнд: Боржигидай-Мэргэн → Монголжин-Гоа, Шар нохой³ → Алан-Гоа.

1. *Боржигин* хэмээх овгийн нэр «Монголын нууц товчоо» (цаашид МНТ гэх)-нд гурвантаа тохиолддогийн хоёр нь *Боржигидай-Мэргэн* [Rachewiltz 1972: 13] (“Мэргэн” гэдэг нь “тэргүүн” гэсэн утгаар буюу “боржигинчуудын тэргүүн”) гэдэг нэрд байгаа бол нөгөө нэг нь Бодончар гэдэг нэртэй холбоотойгоор хэрэглэгджээ. Тэр нь «боржигин овгийн тэргүүн» гэхэд орсон байдаг. (монг. *Bodončar borjigin oboqtan bolba* [Ibid.: 20]). Гэхдээ Боржигидай-Мэргэний гэргий нь Монголжин-Гоа байсныг гэрлэгч хосуудын хувиар бодвол, монгол ба боржигин овгийн хүмүүс болох нь харагдаж байна. Харин тэднийг харь овгоос ураг холбодог байсан дундад зууны үеийн монголчууд гэж үзвэл, боржигинчуудыг монголчуудын бүрэлдэхүүнд багтаан үзэх боломжгүй байна. Нөгөө талаас нь үзвэл, энэ бол өөр өөр овгууд юм. Хэрвээ эмийн тал *монгол* нэрээр

¹ Тус өгүүллийг “Монгольские языки - История и современность. РАН. Институт Лингвистических Исследований. Санкт-Петербург, Нестор-История, 2013, 106-110” сэтгүүлээс орчуулав.

² Зохиогч МНТ-ны хөрвүүлэгт буй “Гоа” хэмээх үг нь угтаа “ухаа” гэдэг үгээс хувьссан “Qo'ai” гэсэн хэлбэртэй дундад үеийн монгол хэлний үг байсныг нягтлаагүй бололтой.

³ Добу Мэргэн (Д.С)

тэмдэглэгдсэн бол түүний угсаатны нэрийг дагалдан, ураг холбогч-эрэгтэйчүүд нь өөр угсааных байдаг. Үүнийг утгазүйн эгнээ тогтсон хослолоор дэлгэрүүлбэл: *тайчууд* – *монгол* = *нукуз(?)* – *хиад* = *боржигин* – *монгол* = *боржигин* – *хиад* = *эр* – *эм* = *Бөртэ-Чино* – *Гоа-Марал* гэх мэтээр өвөг хэлбэр нь бүхий л хослолуудад хадгалагдаж байна. Үүгээр хосын нэгдэх бүрэлдүүлэгч нь түрэг хэлтний угсааных: *тайчи*, *бор* (“бор” – түрэг хэлнүүдэд “чоно”.)

Аравдахь үед байгаа Хорилардай-Мэргэн, Баргужин-Гоа гэсэн хосыг авч үзвэл, эрэгтэй талын удам нь түрэг угсаатны шинж (*хори*) агуулсан, харин эмэгтэй талын нэр нь монгол гаралтай болохыг зааж байгаа нь хойшид Монголын их гүрэн болтлоо өргөжсөн нэгдлийн гол цөм нь хоёр хэсгээс бүрдэл болсон гэж хэлж болох юм.

2. Мэдээж түрэг хэлний нийгэм-улс төрийн үгийн сан нь монгол хэлний зохих нэр томьёонуудтай ихээхэн холбоотой. Би Хорилардай-Мэргэнтэй хамт орж ирсэн бүлгийн угсаа гарвалын шинжид анхаарал хандуулахыг хүссэн билээ. (*tede bōlōk irgen ber kölbarqujin-tōgūm-iin ejen barqudai-mergen-nū ökin barqujin-go'a neretei ökin-ni qori-tumad-un noyan qorilartai-mergen-ne ökdeksen aju'u*) [Rachewiltz 1972: 14].

2.1. Янз бүрийн угсаатны бүлгүүдийн удирдагчдын цол хэргэмийн ялгаа анхаарал татаж байна: Баргынх *ejen*, хори-түмэдийнх *noyan*, энэ нь тэдний янз бүрийн үүргийг (байгаа баримтуудыг үндэслэн үүнийг тодорхойлох аргагүй юм) заасан байж болох ба мөн угсаа-соёл ба хэлний ялгаатай ч холбоотой байж болох юм. Харин сүүлд 17-р зууны бичигт Хорилардай-Мэргэнийг *ejen* [АТ 9] гэж бичсэнээс үзвэл, энэ хоёр цол хэргэмийн утга ойролцоо юм хэмээн тааварлаж болохоор байна.

2.2. Миний бодлоор Баргудай-Мэргэнийг нуурын (*köl* – түргээр тэмдэглэсэн⁴) орчмоор нутаглаж байсан, баргын нэгэн хэсэг болох *köl-barqujin-tōgūm* удмын тэргүүн болохыг тэмдэглэсэн. Энэхүү *tōgūm* гэдэг үг *uruu* гэсэн үгтэй утга ойролцоо бөгөөд иран хэлнээс түрэг хэлнүүдэд нэвтэрсэн “үр, мөхлөг; овог, төрөл, үр удам” [СИГТЯ 1997: 116] гэсэн утгатай үг юм. Харин *-jin* дагавар нь *barqu* гэсэн нэр үгээс тэмдэг нэр бүтээх дагавар мөн.

Түүний бэлхэн баталгаа нь халимаг хэлэнд бий: Калм. *təxt* ‘Үндэс угсаа, овог аймаг, удам’ (KWb 397b), Орчин үеийн. калм. *təxt* ‘үүлдэр’ (Мун. 510), ойр. Шинж. *Təxət* ‘овог, төрөл, үе, гарал’ (Тодаева 335); – түрэг хэлнүүдэд байгааг

⁴ Байгаль нуурын нэрийг судлаачид бай “баян” + көл “нуур” гэсэн утгатай түрэг үгсээс бүтсэн гэж үздэг. (ДС)

харьцуулбал., каз. *tuqim* ‘үр мөхлөг; үр удам; гэр бүл; үр хөрөнгө; үр жимс; үе;’, кир. *tukum* ‘үр мөхлөг, үр хөрөнгө’, тат. *tokim* ‘үүлдэр; үр удам’ [Kempf 2012: 144].

2.3. МНТ-нд байгаа *bölök* гэдэг үгийг би ч бас Хорилардай-Мэргэний “удам угсаа” хэмээн орчуулсан. Миний бодлоор, буриадын уламжлалт соёлд хадгалагдаж буй утгаар ойролцоо *bölök, uruу* гэсэн хоёр үгийг энэ маягаар тайлбарлаж болох юм. Сурвалж бичгийг хөтлөгч Вандан Юмсунов бичихдээ: хори *хоорондо обог обогоор гу. Али яһаар болон бүлэг айлнуудаар хамтаран нийлэгэд* [БТБ 75] гэжээ. Энд бид хори (овог) – овгууд (*обог обогоор*) – удам (*яһаар* = *бүлэг айлнуудаар, уруг* гэдэг үгийн адилаар) гэсэн бүтцийг харж байна.

3. Боржигинчууд түргүүдтэй угсаатны нийтлэг нэг болохыг үзүүлэх нэмэлт нотолгоо баримтын түлхүүр нь Бодончарын нэр бөгөөд түүнийг угсаатны энэ бүлгийн уг язгуур хэмээдэг юм. Тэрээр Алан Гоагийн отгон хүү байсан нь тодорхой. Энэ *Бодончар* хэмээх нэр хоёр хэсгээс бүтэж буй бөгөөд эхний хэсэг бодон нь ‘зэрлэг гахай’ [Rachewiltz 2004/1: 260], удаах хэсэг *чар* нь миний ойлгож буйгаар түргийн ханлигийн хэргэм, цолд буй *чор*⁵ гэдэг үгийн хувирсан хэлбэр юм. Э.Шаваннаг эшлэн С.Г.Кляшторный бичихдээ: «Дорно зүгийн хэсэг нь дудугийн таван овог гэж нэрлэгдэж байсан ба тэднийг агуу их таван чор толгойлж байв» [Кляшторный, Савинов 1994: 19]. Ышбара Хилаш-ханы 634 онд явуулсан шинэчлэлийн тухай С.Г.Кляшторный бичсэн эхийг цаашид уншин үзвэл, *иркинүүд* болон *чорууд* нь овгийн ахлагч нар байжээ. [Тэнд: 23]. Энэ бүхнээс үүдэж миний бие Бодончар (Бодон-чор) Алан-Гоагийн отгон хүү байсан тул түрэг хэлтэй боржигин – тайчууд овог (бүлэг)-ийн аль нэгээс нь удирдагч болсон хэмээн таамаглаж байна. Хэргэм зэрэг дорно дахин, дорно зүгийнхэнтэй холбогдоход отгонтой нь хамаатай байдгийг харгалзан үзвэл, Бодончар бага хүүгийн ёсоор гал голомтыг залгамжилсан хэмээн үзэж болно. Дурдсан *-чар* бүтээвэр нь түргийн хэргэм зэрэг заасан *чор* гэдэг үгийн монгол хувилбар байж болох тухай миний таамаглалын нотолгоо нь эх сурвалжийн хэрэглэгдэхүүнүүдэд тохиолдож буй энэ хэлбэрийг агуулсан нэр юм. Энэ цол хэргэмийг хэрэглэж явсан хүмүүс нь голдуу дорно зүгт хамаарч байсан бөгөөд мөн ураг удмын отгон нь байжээ. Хэдийгээр *-чар* хэлбэр нь дан ганц отгон хүү болохыг тодорхойлох үүрэгтэй хэрэглэгддэг боловч, тус эх сурвалжууд бас зонхилгч хандлагатай болохыг нь нотолж байна.

⁵ П.О. Рыкины *-чар/-нчар* гэдэг дагаврын утгын талаар бичсэн өгүүлэлтэй холбон “-чар” дагаврын тухай миний үзэл баримтлалыг хэлэлцэх нь энэхүү материалын хэмжээ багтаамжийн хязгаарлалтаас хамааран боломжгүй зүйл гэж би үзэж байгаа боловч түүнийг [Рыкин 2009; Rykin 2010] ерөнхийд нь хүлээн зөвшөөрч байна.

Тус бүтээлд толилуулж буй хэрэглэгдэхүүнүүд нь Монголын эзэнт гүрний цөм бүрэлдэн тогтоход түрэг угсаатны оролцоо хэчнээн чухал байсныг харуулж байгаа юм.

Орос хэлнээс орчуулсан: Д.Соронзон (Ph.D)

МУБИС. НХУС. Монгол хэлний тэнхим

Товчилсон нэрсийн жагсаалт

БТБ – Бурядай туухэ бэшэгуудэ (Бурятские исторические хроники) / Сост. Ш.Б.Чимитдоржиев. Улан-Удэ, 1992.

СИГТЯ 1997 – Сравнительно-историческая грамматика тюркских языков: Лексика / Отв. ред. чл.-корр. РАН Э.Р. Тенишев. М., 1997.

ТИМ – «Тайная история монголов» [Rachewiltz 1972].

АТ – Altan Tobči: A Brief History of the Mongols by bLo-bzañ bsTan-‘jin, with a Critical Introduction by The Reverend Antoine Mostaert, C.I.C.M., Arlington, Virginia, and an Editor’s Foreword by Francis Woodman Cleaves, Associate Professor of Far Eastern Languages, Harvard University. Cambridge MA, 1952. (Scripta Mongolica; 1.)

Ном зүй

Кляшторный, Савинов 1994 – *Кляшторный С.Г., Савинов Д.Г.* Степные империи Евразии. СПб., 1994.

Крадин, Скрынникова 2006 – *Крадин Н.Н., Скрынникова Т.Д.* Империя Чингис-хана. М., 2006.

Рыкин 2009 – *Рыкин П.О.* Об этимологии терминов родства с суффиксом .ᠵА(r~g) ~ пᠵА(r~g) в монгольских языках // Алгебра Родства. Родство. Системы родства. Системы терминов родства. СПб., 2009. Вып. 12. С. 195–207.

Скрынникова 1993 – *Скрынникова Т.Д.* Этнотопоним *Баргуджин-токум* // История и культура народов Центральной Азии. Источниковедение: Сб. ст. Улан-Удэ, 1993. С. 41–50.

Kempf 2012 – *Kempf B.* Kalmyk – Semantical Categories of Turkic Elements in Kalmyk // Oirad and Kalmyk Linguistic Essays / Ed. By Á. Birtalan. Budapest, 2012. P. 134–162.

Rachewiltz 1972 – *Rachewiltz I. de.* Index to The Secret History of the Mongols. Bloomington, 1972. (Indiana University Publications: Uralic and Altaic Series; Vol. 121.)

Rachewiltz 2004 – The Secret History of the Mongols: A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century / Transl. with a Historical and Philological Commentary by I. de Rachewiltz. Leiden; Boston, 2004. Vol. 1–2. (Brill’s Inner Asian library; Vol. 7/1–2.)

Rykin 2010 – *Rykin P.* Towards an etymology of Middle Mongolian *Bodončar* ~ *Bodančar* // Mongolo-Tibetica Pragensia ’10: Ethnolinguistics, Sociolinguistics, Religion and Culture. 2010. Vol. 3, № 1. P. 105–122.